



**ОРОСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
Дорно дахины гар бичмэлийн  
хүрээлэн**



**МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
Түүх, археологийн хүрээлэн**

# **Б.Я.ВЛАДИМИРЦОВ - XX ЗУУНЫ НЭРТ МОНГОЛЧ ЭРДЭМТЭН**

**ОХУ-ын Санкт-Петербург хотноо  
2014 оны 10 дугаар сарын 6-8-нд  
зохион байгуулсан олон улсын  
эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл**

**Улаанбаатар хот  
Санкт-Петербург хот  
2015**



**РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК**  
**Институт восточных рукописей**



**МОНГОЛЬСКАЯ АКАДЕМИЯ НАУК**  
**Институт истории и археологии**

**Б.Я.ВЛАДИМИРЦОВ -**  
**ВЫДАЮЩИЙСЯ МОНГОЛОВЕД**  
**XX ВЕКА**

**Материалы российско-монгольской**  
**научной конференций**  
**6-8 октябрь. 2014 г.**

**Санкт-Петербург**  
**Улан-Батор**  
**2015**



**RUSSIAN ACADEMY  
OF SCIENCES**  
Institute of Oriental Manuscripts



**MONGOLIAN ACADEMY  
OF SCIENCES**  
Institute of History and Archaeology

**B.YA.VLADIMIRTSOV -  
THE OUTSTANDING RESEARCHER  
OF MONGOLIAN STUDIES  
IN THE 20<sup>TH</sup> CENTURY**

**PROCEEDINGS**

**International Conference  
October 6-8, 2014. St. Petersburg, Russia**

**Ulaanbaatar, Mongolia  
St. Petersburg, Russia  
2015**

DDC  
900.015  
В-573

*Оросын Шинжлэх Ухааны Академийн  
Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл,  
Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн  
Түүх, археологийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн баталснаар хэвлэв.*

**Ерөнхий редактор:** түүхийн ухааны доктор (Ph.D) *С.Чулуун*  
**Эмхтгэгч, ерөнхий редактор:** хэл шинжлэлийн ухааны доктор (Sc.D) *И.В.Кульганек*  
**Англи эхийн редактор:** хэл шинжлэлийн доктор (Ph.D) *Д.А.Носов*  
**Шүүмжлэгч:** түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D) *Т.Д.Скрынникова*  
хэл шинжлэлийн ухааны доктор (Sc.D) *Л.Г.Скородумова*  
түүхийн доктор (Ph.D) *В.Ю.Жуков*

**Б.Я.Владимирцов – XX зууны үеийн нэрт монголч эрдэмтэн:** өгүүлийн эмхтгэл. 2014 оны 10 сарын 6-8-ны хооронд Санкт-Петербургт зохион байгуулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. *Санкт-Петербург; Улаанбаатар, 2015. 218 х.*

Тус эмхтгэлд Санкт-Петербург хотноо Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнд Монгол судлалыг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр Оросын нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын 130 жилийн ойд зориулан зохион байгуулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурлын үр дүн болсон өгүүллүүд багтсан болно. Б.Я.Владимирцовын бүтээлийн өвийг түүхч, хэл шинжээч, утга зохиол судлаач, соёл судлаач, улс төр судлаач нар төдийгүй Монгол судлалын салбаруудын бэлчир дээр судалгаа шинжилгээ явуулдаг хэн бүхэн өргөнөөр ашиглаж ирсэн юм. Энэхүү хурал нь Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн болон Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан хоёрдугаар хурал болно. Эмхтгэлд Оросын болон Монголын судлаач нарын монголчуудын түүх, соёл, хэл утга зохиолын салбарт хамаарах олон асуудлыг хөндсөн өгүүллүүд багтжээ. Хэд хэдэн өгүүлэл нь Б.Я.Владимирцовын Монгол судлалын олон чиглэл салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэхэд чиглэсэн байна. Өгүүлийн ихэнх нь уран зохиолын дурсгалт бичиг, нэр томъёоны асуудал, аман зохиолын ангилал, түүхэн үйл явдлын үнэлэлт, Оросын болон Монголын гар бичмэлийн хөмрөг, архивуудаас олж илрүүлсэн шинэ нээлт зэргийг судлахад зориулагджээ. Иймд тус эмхтгэлийг Орос, Төв Азийн соёл, түүхийг сонирхогч хэн бүхэн болон дэлхийн монгол судлаачдын анхааралд хандуулан өргөн барьж байна.

© ОШУА ДДГБХ, 2015  
© МШУА ТАХ, 2015  
© Зохиогч нар, 2015

ISBN 978-99973-0-619-7

DDC  
900.015  
В-573

*Утверждено к печати Ученым Советом Института  
восточных рукописей Российской академии наук,  
Ученым Советом Института истории и археологии  
Монгольской академии наук.*

**Главный редактор:** кандидат исторических наук **Чулуун С.**  
**Составитель, научный редактор:** доктор филологических наук **И.В.Кульганек**  
**Редактор английского текста:** кандидат филологических наук **Д.А.Носов**  
**Рецензенты:** доктор исторических наук: **Т.Д.Скрынникова**  
доктор филологических наук **Л.Г.Скородумова**  
кандидат исторических наук **В.Ю.Жуков**

**Б.Я.Владимирцов – выдающийся монголовед XX века:** сборник статей.  
Материалы российско-монгольской науч. конф. 6–8 окт. 2014 г.  
Санкт-Петербург. – СПб.; Улан-Батор, 2015. – 218 с.: ил.

В сборнике представлены статьи, отразившие итоги работы российско-монгольской научной конференции, прошедшей в Институте восточных рукописей РАН в Санкт-Петербурге при поддержке Фонда развития монголоведения в Монголии и посвященной 130-летию Б.Я.Владимирцова, выдающегося российского ученого-монголоведа, значение научных трудов которого до настоящего времени чрезвычайно велико. Его трудами пользуются историки, лингвисты, литературоведы, культурологи, политологи и ученые, проводящие исследования на уровне новых междисциплинарных наук. Данное мероприятие явилось второй международной конференцией, организованной Институтом истории МАН совместно с Институтом восточных рукописей РАН и стала результатом сотрудничества монгольских и российских ученых. В сборник включены статьи российских и монгольских исследователей по различным проблемам истории, культуры, литературы и языка монгольских народов. Ряд статей посвящены роли Б.Я.Владимирцова в исследовании различных аспектов монголоведения. Большая часть статей касается вопросов издания конкретных литературных памятников, использования терминов, классификации фольклорных произведений, художественных особенностей и образной системы поэтического творчества, анализа конкретных исторических событий и их научной интерпретации, новых открытий в рукописных фондах и архивах России и Монголии. Сборник рассчитан на монголоведов и всех, интересующихся историей и культурой России и Центральной Азии.

© ИВР РАН, 2015.

© ИИ МАН, 2015.

© Коллектив авторов, 2015.

ISBN 978-99973-0-619-7

DDC  
900.015  
B-573

*The publication is approved by the Academic Council of Institute of Oriental Manuscripts, Russian Academy of Sciences and by the Academic Council of Institute of History, Mongolian Academy of Sciences.*

**Editor-in-Chief:** Ph. D (history) *Chuluun S.*  
**Compiled and edited by:** Sc. D (philology) *I.V.Kulganek*  
**Texts in English edited by:** Ph. D (philology) *D.A. Nosov*  
**Reviewers:** Sc. D (history) *T.D. Skrynnikova*  
Sc. D (philology) *L.G. Skorodumova*  
Ph. D (history) *V.Yu. Zhukov*

**B.Ya. Vladimirtsov – the Outstanding Researcher of Mongolia in the 20th Century.** Proceedings of International Conference October 6–8, 2014. St.Petersburg, Russia. Ulaanbaatar–St.-Petersburg. 2015. 218 P.

The proceedings reflect the results of international research conference, taken place at the Institute of Oriental Manuscripts, RAS (St. Petersburg, Russia). It was supported by the National Foundation for Mongolian Studies (Government of Mongolia). The conference was dedicated to the 130th anniversary of B.Ya. Vladimircov, an outstanding mongolist, who influenced greatly all fields of Mongolian studies. His works are of great importance for historians, linguists, researchers of literature, culture and politics, as well as for interdisciplinary studies. This gathering was the second international conference, held by the Institute of History, Mongolian Academy of Sciences in cooperation with the Institute of Oriental Manuscripts, Russian Academy of Sciences. These proceedings are collection of articles, written by Russian and Mongolian scholars on different problems of history, culture, literature and languages of Mongolian peoples. Some of the articles are dedicated to the role of B.Ya. Vladimircov in different fields of Mongolian studies. Most of the articles answers questions on publishing exact literary monuments, terminology, classification of folklore texts, analysis of poetics, research and interpretation of different historical events, new discoveries in archives and manuscripts' collections in Russia and Mongolia. This collection of articles is designed for scholars in Mongolian studies and for everyone, who is interested in history and culture of Russia and Central Asia.

© IOM RAS. 2015.  
© IAH MAS. 2015.  
© Composit authors. 2015.

ISBN 978-99973-0-619-7

## СОДЕРЖАНИЕ

Предисловие ( <i>И.В. Кульганек</i> ) .....	10
---	----

### Приветствия

<i>Попова И.Ф.</i> директор Института восточных рукописей РАН .....	17
<i>Заябаатар Д.</i> Секретарь Фонда развития монголоведения в Монголии. Улан-Батор. Монголия .....	18

### Статьи

<i>Бичеев Б.А.</i> Ойратская версия «Истории Белой Тары» («Повесть о Нарану Герел») .....	22
<i>Бурькин А.А.</i> Б.Я. Владимирцов – основоположник современной научной алтаистики .....	30
<i>Валеев Р.М.</i> Истоки российского университетского монголоведения и буддологии в Казани (первая половина XIX в.) ....	42
<i>Гэрэлбадрах Ж.</i> Было ли «унгу боол»? .....	50
<i>Дашням Л.</i> К вопросу о классификации мудрых слов в монгольском языке .....	61
<i>Дробышев Ю.И.</i> Погодная магия в средневековой Монголии .....	68
<i>Елихина Ю.И.</i> Раскопки С.А. Теплоухова кургана № 12 в Ноин-Уле .....	78
<i>Захарова И.М.</i> Посольство Ю.А. Головкина в Цинскую империю и монгольские акварели А.Е. Мартынова .....	91
<i>Кантор Е.А.</i> Монгольский перевод «Мани-Кабума», выполненный Гуши Цорджи (1608) .....	102
<i>Кукеев Д.Г.</i> Некоторые сведения о материальном наследии джунгаров .....	110
<i>Кульганек И.В.</i> Представление о счастье в монгольских пословицах и поговорках .....	121
<i>Мунхицэцэг Э.</i> Некоторые термины в книге Б.Я. Владимирцова «Общественный строй монголов» и в словаре «Зерцало маньчжуро-монгольской словесности, изданное по высочайшему повелению» (1717) .....	129
<i>Носов Д.А.</i> Б.Я. Владимирцов как основоположник современной монголоведной фольклористики .....	137

<b>Носов Д.А., Почекаев Р.Ю.</b> Рукопись Ц.Ж. Жамцарано из фонда ИВР РАН «Отрывок о том, как вести тяжбу» – источник по истории монгольского права .....	144
<b>Петрова М.П.</b> Модернистские тенденции в монгольской поэзии конца XX– начала XXI в.. .....	153
<b>Түвшинтөгс Б.</b> Тод бичгээрх бар хэвлэлийн уламжлал .....	164
<b>Туранская А.А.</b> Национально-культурные особенности монгольского перевода «Гурбума» Миларэпы .....	178
<b>Чулуун С.</b> Изучение обнаруженного в Монголии неизвестного списка «Шара Туджи» .....	185
<b>Юрченко А.Г.</b> Сакральная арифметика и численность армий Чингизидов .....	200
Сведения об авторах .....	215



## CONTENTS

Foreword ( <i>by I.V. Kulganek</i> ) .....	10
--	----

### Greetings

<i>Popova I.F.</i> Director of Institute of Oriental Manuscripts RAS .....	17
<i>Zayabaatar D.</i> Secretary of the National Foundation for Mongolian Studies (Ulaanbaatar, Mongolia) .....	18

### Articles

<i>Bitcheev B.A.</i> Oirat version of «Tale of Naranu Gerel» («Tale of White Tara») .....	22
<i>Burykin A.A.</i> B. Vladimirtsov – founder of modern Altaic studies .....	30
<i>Valeev R.M.</i> Origins of the Mongolian and Buddhist Studies in Kazan University (the first half of 19 century) .....	42
<i>Gerelbadrakh Zh.</i> Was there an «ongu bool»? .....	50
<i>Dashniam L.</i> On the Classification of the wise Words in Mongolian .....	61
<i>Drobyshev Ju.</i> Weather magic in medieval Mongolia .....	68
<i>Jelikhina Ju.</i> S.A. Teploukhov's excavations of the mound number 12(24) in Noin-Ula, Mongolia in 1924 .....	78
<i>Zakharova I.M.</i> The embassy of the count Y.A. Golovkin to the Qing Empire and Mongolian watercolors by the artist A.E. Martynov .....	91
<i>Kantor E.A.</i> Mongolian translation of the «Mani Kabum» by Guusi Čorji (1608) .....	102
<i>Kukeev D.G.</i> Some information on material heritage of the nomadic population of Jungar Khanate .....	110
<i>Kulganek I.V.</i> The idea of happiness in the Mongolian Proverbs and sayings .....	121
<i>Munkhtsetseg E.</i> Some terms in B.Ya Vladimirtsov's book «Social structure of Mongols» and in the dictionary «Qayan-u bičigsen manju mongyul ugen-u toli bičig» (1717) .....	129
<i>Nosov D.A.</i> B.Ya. Vladimirtsov as father founder of modern studies in Mongolian folklore .....	137
<i>Nosov D.A., Pochekaev R.Yu.</i> Manuscript «The fragment on court order...» from Ts. Zamtsarano's collection (IOM RAS, St. Petersburg) as a source on the Mongolian law history .....	144

<b><i>Petrova M.P.</i></b> Modernist Trends in Mnglian Poetry of the late 20th – early 21st. centuries .....	153
<b><i>Turanskaya A.A.</i></b> National and cultural peculiarities of Mongolian translation of Milarepa's «Gurbum» .....	164
<b><i>Tuvshintugs B.</i></b> The tradition of printing block in clear script .....	178
<b><i>Chuluun S.</i></b> The study of the newly discovered «Shar tuuj» found in Mongolia .....	185
<b><i>Yurchenko A.G.</i></b> «Sacred arithmetic» and size of the armies of Chingizids .....	200
Notes on authors .....	215

Б.Түвшинтөгс  
Хэл зохиолын хурээлэн МУ ШУА  
Улаанбаатар, Монгол улс

## ТОД БИЧГЭЭРХ БАР ХЭВЛЭЛИЙН УЛАМЖЛАЛ

*Аннотация.* Прошло уже свыше ста лет, как учёные начала XX столетия, опираясь на конкретные материалы проведённых исследований, опровергли ранее бытовавшую в научных кругах точку зрения о том, что не существовало ксилографического печатания на ясном письме. Однако до сих пор не было издано существенных трудов, проливших свет на традиции ксилографического печатания сутр на ясном письме, их обзора, а также роли и места монголов в истории мирового книгопечатания. Другими словами, хотя исследователи, проявляя живой интерес к делу изучения монгольской литературы и книгопечатания, посвятили им свои многочисленные труды, в них дано лишь только поверхностное, краткое освещение вопросам ксилографического печатания сутр на ясном письме. В данной статье мы задались целью дать общий обзор ксилографического книгопечатания на ясном письме.

*Ключевые слова.* Ясное письмо, книгопечатание, традиции, ксилографирование.

B. Tuvshintugs

## THE TRADITION OF PRINTING BLOCK IN CLEAR SCRIPT

*Abstract.* The view that books were not printed in Clear script has been denied by researchers since the beginning of XX century and taken more than 100 years. But there have not been any substantial works that clarifies tradition of printing books in Clear script, survey about books and sutras as well as status of printing block in Clear script in Mongolians literary history. In other words, only some researchers briefly mention about it in their works. The author aims to introduce the survey about the printing books in Clear script.

*Key words.* Clear writing, typography, traditions, woodcut

Тод бичгээр ном барлаж байгаагүй хэмээх үзэл байсныг XX зууны эхэн үеэр судлаачид баримтаар үгүйсгээд 100 гаран жил болох гэж байна. Гэвч энэ хугацаанд тод бичгээр ном барлаж ирсэн уламжлал, ном судрын тойм, монголчуудын ном хэвлэлийн түүхэнд эзлэх тод бичгээрх бар хэвлэлийн

байр суурь зэргийг тодруулан авч үзсэн, нэгтгэн дүгнэсэн дорвитой бүтээл гараагүй өдий хүрэв.

Тод бичгийг хэдийд зохиосон талаар Зая бандида Намхайжамцын намтар «*Равжамба Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршив*» гэдэг зохиолд «Тэр жилийн өвөл Авлай тайж Чүйд /Зая бандидатай/ хамт өвөлжив. Тэр хулгана жилийн өвөл /Зая бандида/ тодорхой үсэг зохион үйлдэв» гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд бусад түүхэн үйл явдлуудын он цагтай харьцуулан үзээд тод бичгийг зохиосон хулгана жил нь аргын 1648 он болохыг судлаачид санал нэгтэй хүлээн зөвшөөрч байна. Тэрбээр тод бичгийг юуны учир, хэрхэн зохиосон тухайгаа «Үсгийн найрлага» хэмээх цагаан толгойн төгсгөлийн үгэнд тун тодорхой өгүүлсэн байдаг ба ийм үсгийг зохиосноор шашин өргөжин дэлгэрч амар амгаланг олохыг хүсэн ерөөжээ. Тийм ч учраас Зая бандида Намхайжамц таалал төгсөх 1662 он хүртэлх хугацаандаа судар, үндсэн зарлиг, шаштир олныг орчуулсан ба тэдгээр орчуулгын зохиолуудын төгсгөлийн үгээс үзвэл шашин номд тус болох үүднээс тухайн үеийн нийгэмд тэргүүлэх байр суурь эзэлж байсан хүмүүс ном орчуулахыг хүсэн дурдаж байсныг мэдэж болдог. Бас орчуулсан номыг нь хуулан олшруулж нийтийн хүртээл болгож байсан бөгөөд ийнхүү нэг номоос хуулан олшруулахыг «ном салгах» хэмээн нэрийдэж байжээ. Харин энэхүү намтарт тэдгээр ном судрыг барлан хэвлэж байсан талаар дурдаагүй билээ. Иймд судлаачид Зая бандидыг амьд сэрүүн ахуйд ойрадууд тод бичгээр ном судар барлаж байгаагүй, хожим Зүүнгарын хаант улсын хүчирхэгжлийн үед л цөөн тооны ном хэвлэж байсан бололтой хэмээн дүгнэсэн билээ.

Тод бичгээрх бар хэвлэлийн талаар монгол судлалын бүтээлд анх Б.Лауфер тэмдэглэн үлдээсэн юм. Тэрбээр 1907 онд «*Skizze der Mongolischen Literatur*» хэмээх бүтээл туурвиж, энэхүү зохиолдоо:

Бээжингээс гадна Өргөө, Хөххотод монгол ном хэвлэдэг боллоо. Ер нь Монголд ном хэвлэдэг олон тооны сүм хийд бий. Буриадуудын тухайд тэд английн шашин номлогчдын нөлөөгөөр загалмайтан болж буй хэдий ч барын хэв сийлэхдээ чадамгай хэвээрээ байсаар. Харин *халимагууд хэзээ ч ном хэвлэж байгаагүй бололтой. Нэг ч халимаг* (өөрөөр хэлбэл тод бичгийн Б.Т.) *хэвлэмэл зүйлтэй би тааралдаагүй ба надтай зөвхөн гар бичмэл л тохиолдож байв* [6, х. 27]

хэмээсэн байна. Энэхүү дүгнэлтийг хийхдээ тэрбээр өргөн уудам Орос орон болон Сибирээр олон жил хөндлөн гулд аяласан нэрт байгаль судлаач, академич П.С.Палласын монголчууд, ялангуяа тэдний баруун хэсэг болох ойрадуудын түүх, угсаатны зүйд зориулсан «*Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften*» хэмээх бүтээлд

Халимагууд дунд би барын хэв сийлж суугаа хүнтэй ер таарсангүй. Монголд ч гэсэн Түвд, Хятадтай харьцуулахад их цөөхөн харж байлаа [4, х.Х; 31, х. 370]

гэж тэмдэглэснийг нотолгоо болгон эш татсан байдаг. Б. Лауфер ийнхүү тод модон барын ном байгаагүй хэмээн дүгнэлт хийхдээ хэдийгээр тодорхой жишээ, бичвэрээр баталгаажуулаагүй ч гэсэн Халимагт модон бар байсан тухай Й. фон Страленберг

1723 онд миний бие Тобольск хотод мужийн ерөнхий захирагч ноён Черкасскийнд яг үүнтэй ижилхэн халимаг модон бар харж байсан [28, х. 312] хэмээн тэмдэглэснийг анзаараагүй бололтой.

Б. Лауферийн дээр дурдсан бүтээл хэвлэгдсэнээс 20 жилийн дараа буюу 1927 онд уг зохиолын орос орчуулгыг ариутган шүүж хэвлүүлэхдээ бичсэн өмнөх үгэндээ Б.Я. Владимирцов

Хаана барласан нь тодорхой бус тод бичгийн барын 2 ном Азийн музейд хадгалагдаж байгаа нь ойрадууд ном хэвлэх оролдлого хийж байсныг харуулж байна [4, х.Х]

хэмээн тэмдэглэжээ. Үүнийг тодотгон Н. Поппе

Ленинградд тод бичгээр барласан 18-р зууны үеийн 2 ном бий. Эдгээрийг яг л япон, хятад, монголчуудын адил номыг бүхэл хуудсаар нь модон дээр сийлсэн хэвээр барласан байна. Харин Б. Лауферийн монгол утга зохиолын түүхийн тухай бүтээлд ойрадууд ном хэвлэлийг ер мэддэггүй хэмээсэн нь бий. Ленинград хотноо тод бичгийн барын ном хадгалагдаж байгаагаас үзэхэд түүний энэ үзэл тийм ч оновчтой биш санагдаж байна. Австрийн эрдэмтэн, хожим Америк руу цагаачилж тэндээ нас барсан Б. Лауфер үнэндээ цөөн тоотой тэдгээрийг үзээгүй бололтой. Тиймээс тэрбээр ойрадуудад барламал ном хэзээ ч байгаагүй хэмээн боджээ [13, х. 68]

гэсэн байдаг. Б. Лауферийн «Монголын утга зохиолын найруулал»-аа бичиж байх үес монголын утга зохиолын дурсгалын талаар мэдэх юм уг зохиолд тодорхойлсон хэдэн бүтээлээс халихгүй байсан” [19, х. 246] ба нөгөөтэйгүүр үнэндээ тухайн үед монгол ном судрыг эрхэмлэн хадгалж байсан хөмрөгүүдэд тод бичгийн модон барын ном байгаагүй юм. Харин Б.Я. Владимирцовт 1927 он гэхэд мэдэгдээд байсан тод үсгийн барын 2 судрыг тэрбээр Монголд томилолтоор ажиллаж байхдаа олж авсан нь түүний тайланд тодорхой туссан байдаг. Тэрбээр Монголд ажилласан талаарх тайлангийнхаа ихэнхид нь өөрийн цуглуулсан ном судрын бүрэн бүртгэлийг хавсаргасан байдаг нь “Хүрээлэнгийн (энд ИВР РАН-ийг хэлж байна Б.Т.) монгол хөмрөгийг бүрдүүлсэн түүхийг тодруулахад маш тустайгаар барахгүй монгол бичгийн зохиолууд ямар ямар газар нутагт байсан талаар найдвартай (заримдаа бүр хэрэгтэй) мэдээнүүдийг өгдөг”

[17, х. 265]. Ийнхүү В.Я.Владимирцовын монголоос авч ирсэн судар номууд түүний 5 хөмрөгийн үндсийг бүрдүүлж байгаа ба энэ 5 хөмрөгт нийт 128 нэгж хадгалагдаж байгаагийн 88 нь тод үсгийн дурсгал болно. 1913–15 оны хооронд Монголд байхдаа цуглуулсан монгол номууд түүний III хөмрөгт хадгалагддаг бөгөөд тооны хувьд бусдаасаа бага, өөрөөр хэлбэл 11 нэгж боловч энэхүү III хөмрөг нь агуулга, төрлийн хувьд судлаачдын анхаарлыг илүүтэй татдаг. Учир нь энэхүү цуглуулгад Хан харангуй туулийн тод үсгийн цорын ганц бичмэл хувь байгаа төдийгүй «ойрадууд ном хэвлэх оролдлого хийж байсныг харуулах» [16, х. 30] тод бичгийн модон барын ном бас байна. Өөрөөр хэлбэл

III хөмрөгийн цуглуулга нь зөвхөн монгол бичгээрх утга зохиолын түүхийг нөхсөн байдлаараа сонирхол татдаггүй юм. Энэ хөмрөгт ойрадын модон барын хэвлэлийн түүхийг тодруулах маш ховор барламал ном бий [17, х. 275] юм.

Тэрбээр энэ удаагийнхаа монголд ажилласан тайлангийн хавсралтад бичсэн номын нэрсийн №8-д

Хутагт Майдарын ерөөлийн хаан оршив. Ойр. бар. Ойрадын мэдэгдээд буй модон барын 2 номын хоёрдахь нь [18, х. 934]

гэж тэмдэглэжээ. Харин Б.Я.Владимирцовын тооцож байгаагаар тод модон барын 2 номын нэгдэх нь чухам ямар ном байв аа?

1920 онд Б.Я. Владимирцов Азийн музейн талаарх танилцуулга бүтээлд монгол номын хөмрөгийн тухай бичихдээ

Ойрадуудын дунд бар хэвлэл хөгжөөгүй нь тодорхой тул Азийн музейд тод бичгийн барын ном бараг байхгүй байгаа нь тийм ч гайхмаар зүйл биш юм. Ер нь бараг байхгүйтэй адил гэж хэлэхэд хилсдэхгүй. Учир нь (Азийн) музейд ойрадын модон барын хэдэн хэв, хаана хэвлэсэн нь үл мэдэгдэх ямартаа ч Баруун хойд Монголоос авчирсан шашны агуулга бүхий барын 2 ном л байна. Ер нь л тэднийг тэнд барласан нь эргэлзээтэй бөгөөд бодоод байхад Зүүнгат, магад ч үгүй Аблайн хийдэд хэвлэсэн байж мэднэ [3, х. 81]

гэжээ. Ийнхүү хаанаас олж авч ирснээ нарийн тодорхой заан өгүүлсэн нь тэрхүү нэгдэх барын судрыг мөн Б.Я. Владимирцов өөрөө энэ хүртэлх хугацаанд баруун хойд Монголд ажилласан гурван томилолтынхоо нэгд авчирсан болохыг гэрчилж байна. Үнэхээр 1915 оноос нэг их хойшгүй бүртгэгдсэн байж таарах Б.Я. Владимирцовын II цуглуулгад тод үсгийн модон барын 1 ном буюу *Хутагт билгийн чинад хүрсэн Таслагч Очир хэмээх их хөлгөний судар оршив* гэсэн ном буйг тэрбээр оруулаад *Хутагт Майдарын ерөөлийн хаан* хэмээх тод үсгийн барын номыг мэдэгдээд байгаа тод үсгийн 2 бар хэвлэлийн хоёрдахь нь гэж тооцож байсан бололтой [17, х. 276]. Чухам энэ хоёрыг л дээр дурдсан Б. Лауферийн бүтээлийн орос хэвлэлийн өмнөх

үгэнд онцлон тэмдэглэсэн байх нь. Харин түүний III хөмрөгт хадгалагдаж байгаа *Хутагт Дар эхийн 21 магтаал оршив* хэмээх тод үсгийн өөр нэгэн барын судрыг Б.Я. Владимирцов гар бичмэл хэмээн тэмдэглэсэн, тодруулбал «Гимны в честь Тара, ойр. рук., старинная с миниатюрами» /Дар эхийн магтаал. Чимэр зураг бүхий ойр. гар бичмэл/ [18, х. 934] гэснээс тодорхой байна. Гэвч энэ нь барын судар бөгөөд 21 Дар эхийн зураг сэлтээр чимэглэсэн, тод үсгийн барын номууд дунд өвөрмөц нэгэн бүтээл билээ. Эдүгээ тус хүрээлэнгийн монгол номын хөмрөгт тод бичгээр барласан

Mayidariyin irö:liyin xān orošiboi [Майдарын ерөөлийн хаан оршив]

Xutuqtu biligiḡyin činadu kürüqsen tasulaqči očir kemēkü yeke kölgöni sudur [Хутагт билгийн чинад хүрсэн Таслагч очир хэмээх их хөлгөний судар оршив]

čoqtu čandan [Цогт зандан]

tabun yuumiyin xuringüui züreken [Хутагт билгийн чинад хүрсэн таван юмын хураангуй зүрхэн]

Xutuq-tu darē ekeyin xorin nigen maqtal kemēkü orošibo [Хутагт Дар эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив]

гэсэн 5 ном хадгалагдаж байна [25, х. 5–26].

1961 онд Германы эрдэмтэн В.Хайссиг К.Сагастэр нар «Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten» хэмээх бүтээл хэвлүүлж, энэхүү бүтээлдээ Германд хадгалагдаж байгаа гар бичмэл болон барын номууд дотор тод бичгийн модон барын 4 хуудас, барласан мэдээ бүхий 1 судар байгааг онцлоод Ленинградд байгаа 2 номтой нийлээд тод үсгийн нийт 7 ширхэг судар байна гэж үзжээ [27, х. XIX]. Академич Б. Ринчен «Монгол бичгийн хэлний зүй» бүтээлийнхээ Тэргүүн дэвтэрт «тод үсгийн номд модон бартай байсан нь ганц Очироор огтлогч гэдэг хөлгөн судар» буй хэмээн дурджээ [14, х. 108]. Тухайн үед монгол судлалын бүтээлүүдэд тод үсгийн барын ном (хэдийгээр зарим нь дутуу боловч) ямартаа ч 7 ширхэг байгааг тэмдэглэсээр атал яагаад энд ганц *Очироор огтлогч* байна гэж дурдах болов оо гэсэн асуулт гарч магадгүй юм. Энд бидний бодлоор зохиогч зөвхөн Монголд тухайн үед мэдэгдээд байсан тод барын ганц номын тухай өгүүлсэн бололтой. Тэрбээр энэхүү Очироор огтлогч судрыг хэрхэн олж авсан тухайгаа тодруулан

1928 онд дөрвөдийн Төгс хөлөг Далай ханы өргөөнд Дар эх тэргүүтэн олны дурдсанд Зая бандида Намхайжамцын орчуулсан *Хутагт билгийн чинад хүрсэн Таслагч очир хэмээх их хөлгөний судар*-ын тод үсгээрх барын хэв байхыг үзсэн бөгөөд энэ хэвээс барласан 2 ширхэг судрыг тэрхүү ном орчуулахыг дурдсан Дар эхийн сүүлчийн дүр болох сайхан сэтгэлт эмэгтэйгээс цэнхэр хадгийн хамт гардаж авсан [15, х. 67]



хэмээн тэмдэглэсэн нь буй. Мөн хожим XVI жарны хөх барс жилийн улаан барс сарын цагаан хулгана өдрөөр огноолсон гурван үеийн түүхдээ

«Өвөг эцэг монголтой, бар бичмэлийн олон номтой, тэр дунд Ойрадын Зая бандидын Хар Эрчис, Аалайн (Аблайн Б.Т) хийдэд байх үед орчууллаа гэсэн модон барын сонин Юм гэдэг судартай» [23, х. 135]

хэмээсэн байдаг.

Тод бичгийн барын номыг цуглуулах, мэдээлэх, судлах талаар олон жил дорвитой судалж цөөнгүй бүтээл туурвисан хүн бол эрдэмтэн Х. Лувсанбалдан билээ. Тод бичгийн барын номын тухай монгол судлалд төдий тодорхой баримт бүрдээгүй шахуу байсан 1960-аад оны үед Х. Лувсанбалдан «Тод монгол барын номын тухай» хэмээх өгүүлэл бичиж монгол судлаачид болон ном хэвлэлийн түүх сонирхогчидод тод бичгээр барласан 3, барласан мэдээ бүхий 2 ном олсноо танилцуулсан байна. Тэрбээр энэхүү өгүүлэлдээ тухайн үеийн байдлаар «...тус хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгт давхардсан тоогоор 1000 шахам ном цугларсан байгааг» тэмдэглээд тэдгээрийн дотор «монголч эрдэмтдийн сонорт мэдэгдээгүй, номзүйн бүртгэлд ч огт байхгүй тийм чухаг сонин гар бичмэл цөөнгүй байгаа бөгөөд барын ном ч байна» хэмээжээ. Үнэхээр тод бичгийн модон барын ном ховор, ховор түүнийг олж хамгаалах нь эрхэм, эрхэм ажлыг гардан хийх нь нэн хариуцлагатай болохыг гүнээ ухамсарласан эрдэмтэн маань тэдгээр тод ном дотроос энэ удаад зөвхөн барын номыг нь тусгайлан танилцуулжээ. Үүнд:

1а. Xutuqtu biligiin činadu kürüqsen nayiman mingyatu. 53,5 × 14,5 см. 382 хуудас. Дансны № 592 (1).

1б. Xutuqtu biligiin činadu kürüqsen nayiman mingyatu. 53,5 × 14,5 см. 382 хуудас. Дансны № 455.

2. Xutuqtu dēdū altan gerel sudur-yin ayimagiyin erke-tū xān kemēkü yeke kölgöni sudur. 47.5 × 12.5 см. 120 хуудас. Дансны № 111.

3. Arašāni zürken nayiman üyetü niyuuča ubadisiyin üндүсүн-ēče dötögör keseq xoyitu üндүсүн kemēkü. 53.5 × 11 см. 90 хуудас. Дансны № 3.

4. Köböün baqsi-inu öbörēn šebe-dū ünēn sedkil-ēče jobeji talbiqsani bičiq zürekeni türma kemēkü, 45 × 8.5 см. 25 хуудас. Дансны № 644 (53).

5а. Xutaqtu biligiin činadu kürüqsen tasulaqči očir kemēkü yeke kölgöni sudur. 22.1 × 7.3 см. 55 хуудас. Дансны № 1.

5б. Xutaqtu biligiin činadu kürüqsen tasulaqči očir kemēkü yeke kölgöni sudur. 22.1 × 7.3 см. 55 хуудас. Дансны № 2.

Эдгээр тод бичгийн модон барын 5 (давхардсан тоогоор 7) ном нь тус хүрээлэнгийн тод номын хөмрөгт хадгалагдаж буйг тэмдэглэн үлдээхийн зэрэгцээ тэдгээрийн ижил хувь болон өөр барын ном хаана хадгалагдаж



байгааг мөн дурдсан байдаг. Энэхүү өгүүллийнхээ төгсгөлд Х. Лувсанбалдан дээр дурдсан барын болон барласан мэдээ бүхий судрууд дээр үндэслэн:

«Зүүнгар, Халимагт хэдий үеэс эхлэн тод монгол ном барласан болохыг тодорхойлоход хэцүү боловч <...> ихэнх номыг Галданцэрэн ханы үед барласан байна. <...> Ойрдод тод монголоор барласан ном угаас цөөн болохоос гадна бидэнд уламжлагдаж ирсэн нь бүр цөөн төдий боловч Монголын соёлын үнэт өв болон үлдэх юм» [7, х. 172]

хэмээн дүгнэжээ.

Нүүдэлчин монголчуудын номыг дагнан судалсан эрдэмтэн Д. Кара монголчуудын бичиг үсэг, ном хэвлэл түүнтэй холбогдох соёлын тааларх олон жилийн судалгааныхаа үр дүн болгон хэвлүүлсэн «Книга монгольских кочевников» (Семь веков монгольской письменности) хэмээх бүтээлдээ Зая бандида Намхайжамцын зохиосон тод бичгийн талаар дэлгэрэнгүй өгүүлээд тухайн үеийн нэрээр ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн Ленинградын салбарт хадгалагдаж байгаа тод бичгийн бичвэр бүхий барын модны талаар тодорхой тэмдэглэжээ. Тодруулбал,

ШУА-ийн Дорно дахин судлалын Ленинградын салбарын Монгол номын хөмрөгт (Q 89 дугаартай) саяхан олдсон хоёр талдаа тод бичвэр бүхий барын мод (26,5 × 5,3 см) хадгалагдаж байна. Уг барын мод нь хус бололтой бөгөөд нилээд нарийн хийцтэй, магадгүй XIX зуунд хамаарна. Мөр хоорондын зай жигд биш, ухаас нь ойролцоогоор 3 мм гүн, дундаа бас орхисон хэсэгтэй, модных нь ширхгийн дагуу сийлжээ. Хавтан модны хоёр талд шашны нэгэн зохиолын хоёрдугаар хуудсыг сийлсэн байна. Гэвч энэ бараас хэвлэсэн судар одоогоор олоогүй, хэдий тийм ч миний бие тус хүрээлэнд ажиллаж байхдаа хийсэн дардсыг энд танилцуулж байна. Одоогийн байдлаар мэдэгдээд байгаа ойрад (халимаг) модон барын ном арав илүүгүй бөгөөд энэхүү барын мод нь энэ төрлийн цорын ганц дурсгал нь болж байна [5, х. 115]

хэмээжээ. Д. Кара ийнхүү уг тод бичвэртэй барын модыг энэ төрлийн цорын ганц дурсгал хэмээн тэмдэглэхдээ Б.Я. Владимирцовын Азийн музейд тод барын мод хэдэн ширхэг байна [3, х. 81] гэснийг анзаараагүй бололтой. Харин Д. Карагийн бүтээлд дурдагдсан барын модууд нь түүний тэмдэглэснээр саяхан олдсон (энэхүү бүтээл 1972 онд хэвлэгдсэн болно) байна [5, х.115]. Тиймээс тэртээх 1920-оод оны модууд биш бололтой. Хожим А.Г. Сазыкин Д.Карагийн танилцуулсан барын модын бас нэг хавтсыг нэмж бүртгэн, улмаар энэхүү барын 2 мод нь «Алтан үсэн хутга там эвдэгч хуурай» хэмээх судрын 2, 8-р хуудасны барын мод болохыг тодорхойлжээ.

Монгол судлалд тод барын мод олдсон нь үүгээр хязгаарлагдахгүй юм. Эрдэмтэн Х. Лувсанбалдан Увс аймгийн орон нутаг судлах музейд тарни сийлсэн тод бичгийн нэгэн барын мод байгааг мэдээлсэн билээ [7, х. 120].

Мөн сүүлийн үед монгол судлалын нарийн нандин дурсгал бүхий Францын Үндэстний номын сангийн Дорно дахины хөмрөгт тод барын 1 хавтас хадгалагдаж байгааг эрдэмтэн Ц.Шагдарсүрэн гэрэл зургаар хэвлүүлжээ. Тэрбээр уг барын модны талаар тодорхой танилцуулж, энэ нь *Хутагт билгийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар*-ын мод болохыг тодорхойлж урьдах судалгаанаас үзвэл энэхүү судар урьд ойрадад гурвантаа барлагдсан бөгөөд тэдгээрийн алинтай нь ч энэ барын модны хэмжээ тохирохгүй байна. Тиймээс наад зах нь энэхүү судрыг дөрвөнтөө барлажээ гэсэн урьдчилсан дүгнэлт хийх боломжийг энэ барын мод олгож байна [29, х. 171] гээд Францын монголч эрдэмтэн Марие-Доминик Эвэний хамт тусгай өгүүлэл хэвлүүлсэн билээ.

Дээр тэмдэглэсэн баримтаас авч үзвэл өнөөгийн байдлаар ОХУ-д 1, Франц Улсад 1, манай орны Увс аймагт 1 тод барын модны хавтас хадгалагдаж байна.

1968 оны 9 сарын 5-6-нд Халимагийн Элиста хотноо тод бичгийн 320 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсан ба тус хурлын илтгэл болон Зая бандида Намхайжамц, тод бичигтэй холбоотой зарим өгүүллийг 1970 онд «320 лет старокалмыцкой письменности: Материалы научной сессии» нэрээр эмхэтгэн хэвлүүлэхэд эрдэмтэн Х. Лувсанбалдан Халимагийн эрдэмтэн А.В.Бадмаевтай хамтран бичсэн «Калмыцкое ксилографическое издание сутры Алтан гэрэл» хэмээх өгүүлэл хэвлүүлж, энэхүү өгүүлэлдээ тод бичгийн модон барын 6 судар шинжлэх ухаанд тодорхой мэдэгдээд байгааг дурдаад

«<...> гэвч Зүүнгарт эсвэл Ижил орчмын халимагуудын хэвлэсэн барын номууд дахин олдоно гэдэгт найдаж байна» [9, х. 85]

хэмээжээ. Тэрбээр цааш нь Алтангэрэл судар монгол хэлтний дунд төдийгүй түрэг хэлт ард түмний дунд өргөн дэлгэрсэн, ялангуяа гар бичмэлээр их тархсан байдгийг онцлон тэмдэглээд

Энэхүү судрын барламал хэвлэл байгаа нь ойрад-халимагуудын бичиг үсгийн дурсгал, дундад зууны үеийн монгол болон халимагуудын соёлын дурсгал болохын хувьд онцгой үнэ цэнэтэй юм [9, х. 86]

гэж үнэлжээ. Ялангуяа тус судрын барламал хэвлэлийн хэвлэн нийтэлсэн мэдээ бүхий төгсгөлийн үг нь Монголчуудын ном хэвлэлийн түүхэнд үнэт мэдээ агуулж байгааг онцолсон байдаг.

Тод бичгийн модон барын номыг зөвхөн халимаг болон баруун монголд хэвлэж байсан төдийгүй бархан бүхий бусад газрын зарим сүм хийдэд ч мөн цөөн тооны бүтээл хэвлэсэн байна. Тухайлбал 1925 онд одоогийн Монгол Улсын Өвөрхангай аймгийн төв оршиж буй Хадатбулаг гэдэг газар байгуулагдсан Үйзэн гүнгийн хийдэд түвд, монгол хоёр хэлээр ном барладаг

тус тусдаа сүмтэй байсан бөгөөд тэнд *Тод-монгол хэмээх үсэг оршив* (10,4 × 44 см, 4 хуудастай) гэдэг тод, монгол хадмал цагаан толгой хэвлэсэн байна.

«Үйзэн гүнгийн хийдийн барын сүм бас хэвлэсэн төвд, монгол судрын-хаа гарчигийг тухай тухайн хэлээр бүртгэн хэвлэдэг байжээ. Тэгэхдээ урт барын гарчиг, дунд барын гарчиг, бага барын гарчиг гэж ангилан бичдэг байсан нь уншигч хүн өөрийн мэдлэгийн хэмжээгээр зохих судрыг олж уншиж, захиалан хэвлүүлэхэд их л дөхөмтэй байжээ. <...> Тэрхүү дурьдсан бүртгэлээс бидний үед хүрэлцэн ирсэн нь нэн ч сонирхолтой юм» [24, х. 200]

хэмээн судлаач Ц.Шүгэр тэмдэглээд тус хийдээс гаргасан «Энэ нь монгол номын урт барын гарчиг болой» гэсэн бүртгэл дэх монгол номын нэрсийн жагсаалтыг гаргажээ. Уг бүртгэлд нийт 46 номын нэр хамрагдсаны №5-д дээр бидний тэмдэглэсэн *Тод монгол хэмээх үсэг оршив* цагаан толгойг «Тод монгол үсгийн 3 мод» хэмээн бүртгэн оруулсан байдаг [24, х. 200; 12, х. 3, 7]. Энэхүү цагаан толгойг эрдэмтэн Х.Лувсанбалдан 1972 онд латинаар галиглаж, гэрэл зургийн хамт хэвлүүлсэн юм [29]. Уг цагаан толгой нь монгол (todoi mongyul kem(e)kü üsüg orošibai), тод (todui mongyol kemēkü üsüq orošiboi), түвд (tho-da mongal zes bya-ba'l yi-ge bzugs-so) бичгээр бүхий гарчигтай монгол, тод хавсарсан цагаан толгой болно. Харин сүүлийн үеийн судалгаагаар мөн хийдэд барласан түвд-тод үсгийн цагаан толгой мэдэгдээд байна.

Х.Лувсанбалдан ийнхүү тод бичгийн модон барын номын талаар хэдэн-тээ тусгайлан тэмдэглэснээс гадна «Тод үсэг, түүний дурсгалууд» бүтээлдээ тусгай зүйл, хавсралт зураг оруулжээ [8, х. 112–122, 316]. Энэхүү номдоо тэрбээр урьд өмнө хэвлүүлсэн өгүүллүүддээ тэмдэглэсэн тод бичгийн барламал болон барласан мэдээ бүхий номуудын талаар нэгтгэн авч үзээд «Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгт одоогоор бэлхнээ байгаа барын ном 12 байгаагаас гадна барласан мэдээ бүхий ном 2 байна» [8, х. 113] гэжээ. Энэ бол тухайн үеийн байдлаар тод бичгийн барын номын талаар монгол судлалд мэдэгдээд байсан бүхий л мэдээ баримтыг нэгтгэн авч үзсэн ач холбогдол бүхий судалгаа билээ. Тухайн үеийн байдлаас үзвэл «1965 оноос хойш Хэл зохиолын хүрээлэнгийн захиргаа тод үсгийн дурсгалыг эрчимтэй цуглуулж» ялангуяа тод бичгийн модон барын хэд хэдэн судартай болсон нь «монгол барын ном хэвлэл нь <...> өвөрлөгч, буриад, Ар Монголоос гадна ойрд монголд дэлгэрч байсныг тодорхойлох» [20, х. 51] бололцоо олгосон юм.

Ховд их сургуулийн багш, ойрад монголчуудын түүх, соёлыг судлагч Б. Батмөнх XVII зууны Монголын их соён гэгээрүүлэгч Равжамба Зая бандида Намайжамцын намтар, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн «Зая бандида Огторгуйн далай» (Уб., 1998<sup>1</sup>; 2004<sup>2</sup>, 2009<sup>3</sup>) хэмээх бүтээлдээ Ховд

Их сургуулийн Монголчуудын бичиг дурсгалын сан болон өөрийн хувьд буй тод бичгийн модон барын судрын талаар тодорхой танилцуулсан байна. Тэрбээр өөрийн гарт буй «Хутагт Дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршвой» гэсэн тод бичгийн модон барын судрын талаар дэлгэрэнгүй танилцуулж [1, х. 99], зохиогчийн тэмдэглэснээр уг судрыг 1996 онд зураач А. Баасанхүү Ховд аймгийн Булган сумын нутгаас олж авчээ. Цаасны хэмжээ 28,5 × 9,3 см, 30 хуудастай. Дийлэнх хуудсанд 8 мөрөөр, 10, 13-р хуудсанд 7 мөрөөр, 14-19-р хуудсанд 15 мөрөөр бичсэн байна. Бас 3-15-р хуудсанд 21 Дар эхийн хөрөгтэй ажээ. Энд тэмдэглэсэн тод бичгийн модон барын судруудын талаар тэрбээр урьд нь мөн тусгайлан өгүүлэл хэвлүүлсэн бөгөөд «<...> эдүгээ бидний үед тод үсгийн нэлээд тооны барын судар олдлоод байгаагаас үзэхэд, Ойрад монголд бар хэвлэл хөгжиж байсан нь илт байна. Гэвч цаашид Монгол болон бусад орны номын сан, архив, музей, хувь хүмүүсийн гарт хадгалагдаж буй тод үсгийн барын ном судрыг сурвалжлан илрүүлэх, тод барын үүсэл, хөгжил, барлах арга технологи зэрэг асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлага зүй ёсоор тулгарч байна» [2, х. 131] хэмээн асуудал дэвшүүлжээ.

Б.Батмөнхийн мэдээлсэн дээрх тод модон барын судруудаас *Хутагт их тонилсны зүгт дэлгэрүүлэгч хэмээх их хөлгөний судар, Хутагт дарь эхийн магтаал оршвой* гэсэн хоёр зохиол урьд нь эрдэм шинжилгээний хүрээнд барласан талаар мэдэгдээгүй байснаараа сонирхолтой юм. Бидэнд буй баримтаас үзвэл Ховд аймгийн Хөгжимт драмын театрын зураач асан М. Амгалан 1981 оны өвлийн тэргүүн сарын 6-д эрдэмтэн Х. Лувсанбалданд нэгэн захидал ирүүлсэн байна. Уг захидалд

Эрхэм хүндэт Жунжаа Танаа, амрыг эрж мэндчилье. Таны захисан тод Тарвачэмбын барын тухай хэдэн үг бичиж явуулав. Үүнд төгсгөлийн үгэнд барласан мэдээ үгүй юм. Уг номын цаас нь 12,5 × 45 см, хуудасны тоо 106 болой. Хэв нь 8,5 × 37,5 см юм. Цаас нь хуучин ойрадын болгосон гэдэг цаас юм [10]

гээд төгсгөлийн үгийг нь сийрүүлэн явуулжээ. Бидний гарт буй зураач М. Амгалангийн захидалд тэмдэглэгдсэн Тарвачэмбо судрын хувь заяа хэрхсэн хийгээд Б.Батмөнхийн мэдээлсэн Тарвачэмбо судар хаанаас олдсон талаар тодорхой мэдээлэл байхгүй тул энэ хоёр судар нэг судар уу, эсвэл нэг судрын өөр өөр хувь уу гэдгийг хараахан хэлэх боломж алга байна.

Халимагийн эрдэмтэн Н. Содмон тод бичгийн хөгжлийн үечлэлийн асуудалд зориулсан өгүүлэлдээ XVII зууны үед модон бараар хэвлэснийг XIX зууны сүүлчээр дахин шинээр модон бар сийлүүлж хэвлэсэн Хутагт билгийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөн судар-ын адил бус хоёр хэвлэл байгааг дурджээ [11, х. 71]. Н.Содмоны тэмдэглэсэн энэ зүйл

бол зөвхөн Шинэжаны тод бичгийн хувирал, өөрчлөлтийг тодруулах баримт болоод зогсохгүй «монголч эрдэмтэд сүүлийн үед олдсон XVIII зуун лугаа холбогдох тод үсгийн цөөхөн модон барын сударт үндэслэн дээр үед ойрадууд ном барлах уламжлал тийм өргөн бус байсан ба Зүүнгарын хаанлиг төр мөхсөний дараа энэ уламжлал тасарсан гэдэг дүгнэлт хийж байсан нь бодтой байдалтай үл нийцэхийг энэ шинэ олдвор гэрчлэж бий» [11, х. 72] юм.

ОХУ-ын Санкт-Петербург хот бол Дорно дахин судлал үүсэн бүрэлдсэн өлгий нутагт зүй ёсоор тооцогдох, ялангуяа монгол судлал, монголын түүх соёл, хэл бичигт холбогдох нарийн нандин эд зүйлийг хадгалж байгаа газар билээ. Нева мөрний баруун эрэг дээр орших Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хөмрөгт буй тод модон барын номын тухай судлаачид тэмдэглэсээр ирсэн бол уг мөрний нөгөө эрэгт орших Санкт-Петербургийн Улсын их сургуулийн Дорно дахины факультетийн эрдэм шинжилгээний номын санд мөн 2 тоотой тод модон барын ном, барласан мэдээ бүхий 1 ном хадгалагдаж байна. Энэ тухай Оросын монголч эрдэмтэн В.Л. Успенский анх мэдээлэн олон нийтэд танилцуулсан билээ [32].

Тод модон барын судар ийнхүү манай орноос гадна ОХУ, Герман улсад байгаагаас гадна БНХАУ-ын зарим байгууллага, хувь хүнд байгаа болохыг сүүлийн үеийн судалгааны бүтээлүүд харуулдаг. Тухайлбал БНХАУ-ын Төвийн үндэстний их сургуулийн багш Мянгад Эрдэмт хичээл зүтгэл гарган ажиллаж цөөнгүй судар ном сурвалжлан олж, хэд хэдэн өгүүлэл нийтлүүлээд байна. Тэрбээр 2005 онд «Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан» эрдэм шинжилгээний сэтгүүлд *Манай улсад хадгалагдаж байгаа тод үсгийн бар хэвлэлийн тухай* гэсэн өгүүлэл нийтлүүлж тус улсад мэдэгдээд буй тод модон барын 22, барласан мэдээ бүхий 3 номын талаар танилцуулж [26, х. 101–113], судлаачдад БНХАУ-д байгаа тод модон барын тухай анх мэдээлсэн билээ. Энэ бол тод модон барын номын тархац, шинэ дурсгал, төрөл зүйлийг баяжуулсан ач холбогдолтой бүтээл болсон юм. Өөрөөр хэлбэл тод модон барын ном хадгалагдаж буй шинэ газрыг олж, урд өмнө судлаачдын мэдээгүй шинэ дурсгалыг танилцуулж, ихэвчлэн шашны сэдэвт бүтээлийг барласан байсныг агуулгын хувьд өөр бүтээл барласан болохыг мэдээлсэн зэргээрээ шинэлэг байв. Доктор Мянгад Эрдэмт уг ажлаа цааш үргэлжлүүлэн 2009 онд нилээд дэлгэрэнгүй томоохон өгүүлэл дахин хэвлүүлсэн [30] байна.

Энэхүү товч өгүүллийнхээ төгсгөлд хэлэхэд, тод бичгээрх модон барын номын тоо тийм ч цөөн биш бөгөөд тэдгээрийн бүртгэл, хадгалагдаж байгаа газар, судалгааны тоймууд эдүгээ нэгтгэн үзэх боломжийг бүрдүүлээд байгаа нь тод бичгээр ном барлаж ирсэн уламжлал, ном судрын тойм, монголчуудын ном хэвлэлийн түүхэнд эзлэх тод барын байр суурь зэргийг тодруулан авч үзэх шаардлагатай байгааг харуулж байна.

## Номзүй

1. *Батмөнх Б.* Зая бандида Огторгуйн Далай: нийгэм-улс төр, шашин, соёлын үйл ажиллагаа. Ред. Д.Дашбадрах. Уб., 2009, 181 х.
2. *Батмөнх Б.* Шинээр олдсон тод үсгийн барын ном судрын тухайд // Тод үсэг-360. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Эрх. А.Батсуурь. Уб., 2008, х. 128–131.
3. *Владимирцов Б.Я.* Монгольский фонд // Азиатский музей РАН. 1818-1918. Краткая памятка. Пг. 1920, с. 74-86.
4. *Владимирцов Б.Я.* Предисловие // Б.Лауфер. Очерк монгольской литературы. Пер. В.А.Казакевича, под ред. и с предисл. Б.Я.Владимирцова. Л., 1927, с. I–XXII.
5. *Кара Д.* Книги монгольских кочевников (Семь веков монгольской письменности) М., 1972, 196 х.
6. *Лауфер Б.* Очерк монгольской литературы. Пер. В.А.Казакевича, под ред. и с предисл. Б.Я. Владимирцова. Л., 1927, с. XXII+96.
7. *Лувсанбалдан Х.* Тод монгол барын номын тухай // SM [Монголын судлал]. Т-VI, fasc. 31. Уб., 1969 [1968], х. 161–172.
8. *Лувсанбалдан Х.* Тод үсэг, түүний дурсгалууд. Ред. Ц. Дамдинсүрэн. Уб., 1975, 356 х.
9. *Лувсанбалдан Х., Бадмаев А.В.* Калмыцкое ксилографическое издание сутры «Алтан гэрэл» // 320 лет старокалмыцкой письменности. Материалы научной сессии. Ред. Д.А.Павлов. Элиста, 1970, с. 80–93.
10. М.Амгалангаас 1981 оны XII сарын 8-д Х.Лувсанбалданд бичсэн захидал. Зохиогчийн хувийн номын санд хадгалагдаж буй.
11. *Намжавин С.* Тод үсгийн түүхийн хөгжлийг үелэн хуваах асуудалд // Монголоведение. № 2. Элиста, 2003, х. 68–81.
12. *Отгонбаатар Р.* Монгол модон барын номын эх гарчиг. Токио. 1998, 144 х.
13. *Поппе Н.* Роль Зая-пандиты в культурной истории монгольских народов (Стенограмма доклада, читанного в Филадельфии 27-го декабря 1958 года) // Kalmyk-Oirat Symposium (Kalmyk Monograph series-2). Philadelphia, 1966, х. 57–72.
14. *Ринчен Б.* Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Удиртгал. Уб., 1964, 250 х.
15. *Ринчэн Б.* Ойратские переводы с китайского // Rocznik Orientalistyczny. Т. XXX. 1. Warszawa, 1966, х. 58–73.
16. *Сазыкин А.Г.* Каталог монгольских рукописей и ксилографов в Институте Востоковедения Академии наук СССР. Т-I. М., 1988, с.30. Энэхүү



эхийн бичил хальсыг Хэл зохиолын хүрээлэнд бэлэглэсэн бөгөөд Х. Лувсанбалдан латин галигийн хамт гэрэл зургаар хэвлүүлжээ. Үз: *Тод үсгийн Хан харангуй* // CMS [Монгол бичвэрийн чуулган]. Т-XX, fasc.1. Хэв. бэлд. Х. Лувсанбалдан. Уб., 1985, 185 тал.

17. *Сазыкин А.Г.* Монгольские рукописи и ксилографы, поступившие в Азиатский Музей Российской Академии Наук от Б.Я.Владимирцова // *Mongolica*. Памяти академика Бориса Яковлевича Владимирцова. 1886–1931. М., 1986, с. 265–297.

18. Список монгольских рукописей, приобретенных от Б.Я. Владимирцова // ИРАН. Новая серия. 1919 (Приложение к протоколу XIV заседания отдела исторических наук и филологии Российской Академии наук 12 ноября 1919 г.).

19. *Хайсиг В.* Монголын утга зохиол // SLL [Хэл зохиол судлал]. Т. VII, fasc. 10. Уб., 1970 [1969]. Орч. Ц. Цэвэлмаа, Д.Ёндон, х. 245–293.

20. *Цолоо Ж.* Ховор ном цугларч байна // ШУА. № 2. Уб., 1967, х. 50–51. Энэ өгүүлэлд мөн «Ойрд нутгаас олдсон тод үсгийн барласан номын хэсгээс» хэвлэсэн байдаг.

21. *Шагдарсүрэн Ц.* Сүүлийн үед Францаас олдсоор буй монгол судлалын зарим эх хэрэглэгдэхүүний тухай // *Acta Mongolica*. Т. 2 (208), Уб., 2003, х. 169–177.

22. *Шагдарсүрэн Ц., Marie-Dominique Ewen.* Тод номын барын нэгэн модон хуудас // Халимаг болон Монголын Ойрадуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд. Эрх. Ц. Шагдарсүрэн. Уб., 2009, х. 131–138.

23. Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Ринчен миний гурван үеийн түүх // Шагдарсүрэн Ц., Адъяа О. Бямбын Ринчен. Монгол Улсын шинжлэх ухаан-5. Уб., 2003, х. 133–147.

24. *Шүгэр Ц.* Үйзэн гүнгийн хошууны барын сүмын тухай товч мэдээ // SLL [Хэл зохиол судлал]. Т. IX, fasc. 19. Уб., 1972, х. 199–202.

25. *Яхонтова Н.С.* Ойратские рукописи и ксилографы в собрании Института Восточных рукописей РАН // Мир ясного письма. Элиста, 2014, х. 5–26.

26. *Erudemuto.* Chyugoku shyozo todo han mongoru bunken nit suite -1749 nen ~ 1949 nen // *Bulletin of Waseda Institute for Mongolian Studies*. 2009, № 5, х. 1–11.

27. *Heissig W., Sagaster K.* Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten // *Verzeichnes der Orientalischen Handschriften in Deutschland*. Band. I. Wiesbaden, 1961, 494 х.

28. *J. von Strahlenberg.* Das Nord und Ostliche Theil von Europa und Asia. Stockholm, 1730.

29. *Luvsanbaldan Ch.* Deux Syllabaires Oïrates //AOH. T. XXV, fasc. 1-3. Budapest, 1972, p.209-219.

30. *Mingyad Erdemtü.* Man-u ulus-tu qadaɣalaydaju bayıɣ-a todı üsüg-ün bar-un keblel-ün tuqai //öbür mongɣul-un neyigem-ün sinjilekü uqayan. 2005, №4 (137), x.107–113.

31. *Pallas P.S.* Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften. Band II.

32. *Uspensky V.L.* Some Rare Oirat Manuscripts in the Collection of the St. Petersburg University Library //Aspect of Buddhism. Liw. 1994, pp.195–202.